



ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 01 сарын 03 өдөр

Дугаар А/03

Улаанбаатар хот

Гадаадын ажиллах хүч, мэргэжилтэнд
хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл
олгох тухай

Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Засгийн газрын "Гадаадаас 2017 онд авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тогтоох тухай" 2016 оны 137 дугаар тогтоолын 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дор дурдсан 2 аж ахуйн нэгж, байгууллагын 18 гадаадын ажиллах хүч, мэргэжилтэнд Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд олгосугай.

Гадаадын ажиллах хүч,
мэргэжилтний тоо

1.1 "Тун гуан майнз констракшн монгол" ХХК	13
1.2 ХНХЯ, "Монгол Улсад ажлын байрыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх төсөл	5

2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж дүнг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд тогтмол мэдээлэхийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дэд дарга /Б.Шижиржаргал/-д, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Т.Есөнтөмөр/-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Б.НЯМДАВАА